

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 4/03

Арвайхээр

В вирус гепатитын эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны “В вирус гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/89 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмч, эмнэлгийн ажилчид болон сайн дурын үндсэн дээр 18-аас дээш насны иргэнийг тархвар судлалын заалтаар В вирус гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

2. В вирус гепатитын эсрэг вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын мэдээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалын дагуу сарын дархлаажуулалтын мэдээтэй хамт сар бүр ирүүлэхийн Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

ЭМГ-ын даргын 2022 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 43 дугаар тушаалийн хавсралт

В ВИРУС ГЕПАТИТЫН ЭСРЭГ ВАКЦИН, ТАРИУРЫН ХУВААРЬ

№	Сумын нэр	Хамрагдах хүний тоо	Шаардлагатай вакцин 2 хүн тунгаар	10 хүн тунгаар савлагдсан вакцин	1 хүн тунгаар савлагдсан вакцин	Нийт олгох вакцин	Тариур /1 мл/
1	БаруунБаян-Улаан	60	120	100	20	120	120
2	Бат-Өлзий	100	200	100	100	200	200
3	Баянгол	60	120	100	20	120	120
4	Баян-Өндөр	60	120	100	20	120	120
5	Богд	100	200	100	100	200	200
6	Бурд	70	140	100	40	140	140
7	Гучин-Ус	60	120	100	20	120	120
8	Зүйл	100	200	100	100	200	200
9	Зүүнбаян-Улаан	60	120	100	20	120	120
10	Нарийнтээл	100	200	100	100	200	200
11	Өлзийт	50	100	80	20	100	100
12	Сант	60	120	100	20	120	120
13	Тарагт	60	120	100	20	120	120
14	Төгрөг	50	100	80	20	100	100
15	Уянга	100	200	130	70	200	200
16	Хайрхандулаан	60	120	100	20	120	120
17	Хархорин	100	200	110	90	200	200
18	Хужирт	150	300	200	100	300	300
19	Нарны дөш	200	400	200	200	400	400
20	Уянсэтгэл	200	400	200	200	400	400
21	Түшигдөлгөөн	200	400	200	200	400	400
	Нийт	2000	4000	2500	1500	4000	4000